

Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах, ашиглах зөвшөөрөл авахад шаардагдах бичиг баримт

Бүрдүүлэх материал:

1. Албан бичиг болон хавсралт хүснэгтээр химийн бодисын нэр томъёо, тоо хэмжээ, импортлох улс, хилийн боомт, зөвшөөрлийн төрлөө тодорхой бичих/ **Хүснэгт 1-ийн загварыг харна уу/**
2. ААН-ийн гэрчилгээний хуулбар нотариатаар батлуулсан байх
3. БОН байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан /эх хувь/, тайландаа тухайн импортлох, ашиглах, хадгалах, худалдах гэж буй химийн бодисын эрсдэлийн үнэлгээг хийлгэсэн байх
4. Импортлож байгаа бол худалдааны гэрээ, тээвэрлэлтийн гэрээ /монгол, англи, орос хэлний аль нэгээр) бусад хэлнээс орчуулсан бол орчуулгын баталгаатай байх
5. Химийн бодисын хор аюулын лавлах мэдээлэл, MSDS /монгол, англи, орос (энэ 3 хэлний аль нэг дээр байж болно.)/ (5 нэр төрлийн бодисоос олон бол CD-д бичих,)
6. Пестицид импортлох бол ХХААХҮЯ-ны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, ариутгал халдваргүйтлийн бодис бол ЭМЯ-ны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хуулбар, тэсэлгээний бодисын түүхий эд химийн бодис бол УУХҮЯ-ны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийн хуулбар
7. Урд авч байсан химийн бодисын ашиглалт, үлдэгдлийн тайлан /**Хүснэгт 2-ын загварыг харна уу/** доорхи email хаягаар илгээх, баталгаажуулсан хуулбар өгөх
8. Мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлт /Химийн бодисын агуулахын дүгнэлт, MNS 6458: 2014 стандартын шаардлагын дагуу гаргасан/
9. Тухайн бодис, түүний хольц хаягдлыг устгах аргачлал, тээвэрлэх арга
10. Хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтанд орсон бодисын зөвшөөрөл, химийн бодис үйлдвэрлэх зөвшөөрөл авахдаа ХХБАББЗАЭҮЗ-ийн ажлын албанаас дүгнэлт гаргуулж, авчирна. (Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолын дагуу)
11. Органик уусгагч импортлох болон үйлдвэрлэх бол харъяалах дүүргийн татварын албанд агаарын бохирдлын төлбөр төлсөн баримт авчирна. (Засгийн газрын 2010 оны 273 дугаар тогтоолын 2 хавсралтын дагуу)
12. Химийн бодисын дагалдах сертификат

Анхаарах: 1 ба 7 дугаар материалын холбогдох хүснэгтийг tsbatjargal@yahoo.com– хаягаар урьдчилан илгээх

ХҮСНЭГТ 1

№	Монгол нэр	Олон улсын нэр	Томъёо	CAS дугаар	Хэмжээ	
					Хүссэн (тн)	Зөвшөөрсөн (тн)
1						

Химийн бодисын ашиглалт, үлдэгдлийн тайланг мэйл хаягаар явуулахаас гадна албан бичгээр тусад өгөхийг анхаарна уу.

ХҮСНЭГТ 2

[illegible]

Тэмдэгтийн хураамж: Данс: 2611184321 Улаанбаатар банк, **Хүлээн авагч байгууллага:** Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс, **Төлбөрийн зориулалт:** Химийн хорт болон аюултай бодисын зөвшөөрлийн тэмдэгтийн хураамж

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль:

21.1.1.Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.4-т заасан жагсаалтад орсон бодисыг импортлох, худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 10 000 000 төгрөг;

ЗГ-ын 2011 оны 199-р тогтоол

11.1.1. химийн хорт болон аюултай бодис **импортлох, хил дамжуулан** тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход:

- 11.1.1.а. 1000 кг хүртэл 1 200 000 төгрөг;
- 11.1.1.б. 1001-10 000 кг 1 500 000 төгрөг;
- 11.1.1.в. 10 001-50 000 кг 1 800 000 төгрөг;
- 11.1.1.г. 50 001-100 000 кг 2 100 000 төгрөг;
- 11.1.1.д. 100 001-150 000 кг хүртэл 2 400 000 төгрөг;
- 11.1.1.е. 150 001-200 000 кг хүртэл 2 700 000 төгрөг;
- 11.1.1.ё. 200 001 кг-аас дээш бол 3 000 000 төгрөг.

11.1.2. химийн хорт болон аюултай бодис **экспортлох, устгах** тусгай зөвшөөрөл олгоход 20 000 төгрөг;

11.1.3. химийн хорт болон аюултай бодис **ашиглах** тусгай зөвшөөрөл олгоход 25 000 төгрөг;

11.1.4. химийн хорт болон аюултай бодис **худалдах** тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

11.1.5. тэсэрч дэлбэрэхээс бусад химийн хорт болон аюултай бодис **үйлдвэрлэх** тусгай зөвшөөрөл олгоход 50 000 төгрөг;

Төрийн сан банк: Данс: 100900013040, **Хүлээн авагч байгууллага:** БОАЖЯ, Байгаль хамгаалах сан, **Төлбөрийн зориулалт:** Гэрчилгээний үнэ, 12500 ₮

